



Монголбанк

Санхүүгийн мэдээллийн алба

# МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАЙЖ БОЛЗОШГҮЙ СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

/Амь насны даатгалтай холбоотой/

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД

ДААТГАГЧ  
БОЛОН  
ДААТГАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН  
ОРОЛЦОГЧ

---

## АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
1. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	5
2. ХАРИЛЦАГЧИЙН ЗАН ТӨЛӨВТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	6
3. САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	7
4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	8
5. ГАЗАРЗҮЙН БАЙРШЛЫН ЭРСДЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	9
6. ХЭВИЙН БУС ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	10
7. ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ ЭСВЭЛ ТАНИХ ШААРДЛАГААС ЗАЙЛСХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	11
8. ГАДААД УЛС ОРОЛЦСОН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	12
9. БУСАД ТАЛУУДЫГ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	13
10. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	14

## ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар мэдээлэх үүрэгтэй этгээд гэж заасан “даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч”-д зориулан гаргав. Эдгээр сэжигтэй гүйлгээний жишээ, шинж тэмдгүүдийг Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан “Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага”-тай хамт үйл ажиллагаандаа ашиглана уу.

Энэ гарын авлагаар амь насны даатгалтай холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний жишээ, шинж тэмдгүүдийг танилцуулж байгаа бөгөөд шинж тэмдгүүдийг дараах байдлаар ангилж хуваасан болно. Үүнд:

1. Харилцагчийг таньж мэдэхтэй холбоотой шинж тэмдгүүд
2. Харилцагчийн зан төлөвтэй холбоотой шинж тэмдгүүд
3. Санхүүгийн гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд
4. Бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой шинж тэмдгүүд
5. Газарзүйн байршлын эрсдэлтэй холбоотой шинж тэмдгүүд
6. Хэвийн бус гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд
7. Гүйлгээг мэдээлэх эсвэл таних шаардлагаас зайлсхийхтэй холбоотой шинж тэмдгүүд
8. Гадаад улс оролцсон гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд
9. Бусад талуудыг ашиглахтай холбоотой шинж тэмдгүүд
10. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой шинж тэмдгүүд

Харилцагчийн гүйлгээ, үйлдэл хэвийн бус, эдгээр сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн нэг болон хэд хэд нь ажиглагдаж байгаа бөгөөд тухайн нөхцөл байдал, өөрчлөлтийг тайлбарлах үндэслэлтэй тайлбар байхгүй тохиолдолд энэ нь харилцагчийн гүйлгээ, үйлдэл сэжигтэй байж болзошгүйг илтгэх дохио болж болно. Сэжигтэй гүйлгээний аль нэг шинж тэмдэг нь дангаараа тухайн гүйлгээг сэжигтэй гэж үзэхэд хангалтгүй байж болох хэдий ч ийм шинж тэмдгүүдийг ажиглах нь даатгалын байгууллагын ажилтанд тухайн харилцагчийг нарийвчлан таньж мэдэх, нэмэлт мэдээлэл, тайлбар авах, өөрт байгаа болон цуглуулсан мэдээллийг харьцуулан тухайн нөхцөл байдал, эрсдэлийг үнэлэх, улмаар Сэжигтэй гүйлгээний тайлан /цаашид “СГТ” гэх/ илгээх шаардлагатай эсэхийг шийдэхэд чухал ач холбогдолтой.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дараах хэсэгт байгаа сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүд нь амь насны даатгалтай холбогдох мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээнд хоёуланд нь хамаатай. Амь насны даатгалын мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх нь харилцагчийг таньж мэдэхээс эхлэх бөгөөд энэ ажилд мэдээлэх үүрэгтэй этгээд /цаашид “МҮЭ” гэх/-ийн сэжигтэй гүйлгээ болон үйл ажиллагааг зөв таниж илрүүлэн СГТ-аар мэдээлэх асуудал чухал үүрэг гүйцэтгэнэ.

Даатгалын байгууллагын хувьд та харилцагч, үйлчлүүлэгч (цаашид “харилцагч” гэх)-д амь насны даатгалын бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх, бизнесийн харилцаа тогтоож, үйл ажиллагаа явуулах явцад энд жагсаасан сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүдийг ажиглаж болно. Таны бизнесийн үйл ажиллагаанаас хамааран эдгээр шинж тэмдгийн зарим нь хамаарахгүй байж болохыг харгалзаж үзэх нь зүйтэй.

Эдгээр жагсаалтыг зөвхөн жишээ, мэдээлэл болгон хүргүүлж байгаа бөгөөд сэжигтэй гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүд эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй, мөн заавал дагаж мөрдөх албагүй болохыг анхаарна уу.



## 1. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагч хүн, хуулийн этгээдийг таньж мэдэх явцад дараах сэжигтэй шинж тэмдгүүд ажиглагдаж болно. Үүнд:

- Харилцагчийг бүрэн, гүйцэт таньж мэдэх боломжгүй эсвэл харилцагчийг тодорхойлох бичиг баримт, мэдээллүүд эргэлзээтэй;
- Харилцагч бүтээгдэхүүн, үйлчилгээ авахдаа МҮЭ-ээс шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, эсвэл төөрөгдүүлсэн, тодорхойгүй, шалгахад хэцүү мэдээлэл өгөх;
- Харилцагчийн өгч буй мэдээлэл, тайлбар нь авцалдаагүй, нөхцөл байдлаас зөрүүтэй байх;
- Харилцагч МҮЭ-д хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл худал, зөрчилтэй, төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгөх;
- Харилцагч нь хуулийн этгээд бөгөөд тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч эсвэл ашиг сонирхлын хяналтыг хэрэгжүүлж буй этгээдийг тодорхойлоход хэцүү бүтэц зохион байгуулалттай байх;
- Харилцагчийн авчирсан, үзүүлсэн баримт бичгийг баталгаажуулах боломжгүй байх (жишээлбэл, гадаад улсад олгогдсон бичиг баримтын хуулбар г.м);
- Харилцагчийн өгсөн хаяг, төрсөн огноо, утасны дугаар гэх мэт мэдээлэл харилцагчийн бичиг баримт эсвэл өөр мэдээллийн эх үүсвэр дэх мэдээллээс нь зөрөх;
- Харилцагч нь хуурамч, засварласан, дууриалган хийсэн эсвэл өөрчилсөн мэт харагдах бичиг баримт ашиглах;
- Харилцагч нь өөрийн оршин суугаа хаягнаас өөр хаяг өгөх эсвэл оршин суугаа хаягаа нуух зорилгоор зөвхөн шуудангийн хаяг гэх мэт тодорхойгүй, харилцагчтай холбогдох боломжгүй хаяг ашиглах;
- Хоорондоо харилцаа холбоогүй мэт харагдах олон харилцагч нэг ижил хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг ашиглах;
- Хоорондоо холбоо хамааралгүй хэд хэдэн харилцагч зочид буудлын нэг ижил хаяг ашиглах;
- Харилцагч нас, орлого, ажил эрхлэлт зэрэг хувийн мэдээлэлтэй нь нийцхээргүй амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах;
- Даатгуулагч болон нөхөн төлбөр хүлээн авагч этгээдүүд хоорондоо холбоо хамааралгүй эсвэл ойлгомжгүй бөгөөд хэвийн бус харилцаатай байх;
- Харилцагч нь хуурамч нэр ашиглах эсвэл хуурамч аж ахуйн нэгж, хуулийн этгээд ашиглан амь насны даатгалын бүтээгдэхүүн худалдан авч байж болзошгүй гэж сэжиглэгдсэн;
- Амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ авах гэж байгаа эсвэл авсан харилцагч нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчил, хууль бус ажиллагаанд холбоотой гэж мэдээлэгдсэн.

## 2. ХАРИЛЦАГЧИЙН ЗАН ТӨЛӨВТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Гүйлгээ хийх явцад харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед цуглуулсан мэдээллүүд болон харилцагчийн гаргаж буй зан байдал, тухайн нөхцөл байдалтай холбогдох мэдээллүүд нь МҮЭ-ийн ажилтныг уг харилцагч, гүйлгээг нарийвчлан судалж шинжлэх, цаашлаад сэжигтэй гэж үзэн СГТ-аар мэдээлэх эсэх шийдвэр гаргахад хүргэж болзошгүй юм. Дараах шинж тэмдгүүд нь харилцагчийн тухайн нөхцөл байдалтай хамаарах зан төлөвтэй холбоотой шинж тэмдгүүд бөгөөд эдгээр шинж тэмдгийг МҮЭ-ийн ажилтан өөрийн хийсэн судалгаа, үнэлэлт дүгнэлт, эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан харьцуулж ашиглаж болох юм.

- Харилцагч гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанд оролцож байгаа тухайгаа мэдэгдсэн эсвэл хүлээн зөвшөөрсөн;
- Харилцагч хуурамч, ташаа мэдээлэл өгсөн / өгч байгаа нь мэдэгдсэн;
- Харилцагч айж, сандарсан байдалтай байх;
- Харилцагч шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах эсвэл зайлсхийх;
- Харилцагч тодорхойгүй, ойлгомжгүй мэдээлэл өгөх эсвэл хийж байгаа гүйлгээ, гэрээний зорилгыг сайн мэдэхгүй байх;
- Харилцагч МҮЭ-ийн ажилтантай нүүр тулж уулзахаас зайлсхийх;
- Харилцагч хэвийн бус эсвэл сэжигтэй байж болзошгүй гүйлгээ хийх, үйлчилгээ авахдаа МҮЭ-ийн ажилтанд мөнгө, бэлэг, хахууль, тусламж санал болгох;
- Харилцагч мөнгөний эх үүсвэрийг тайлбарлахаас татгалзах, эсвэл хуурамч, төөрөгдүүлсэн, илт худал мэдээлэл өгөх;
- Харилцагчийн сонгосон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, давтамж болон төлбөр /шимтгэл, зардал г.м/ нь ердийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардал эсвэл төлбөрөөс өндөр байгаа бөгөөд харилцагч энэ талаар мэдэж байгаа боловч тоохгүй, санаа зовохгүй байх;
- Харилцагч хийж байгаа гүйлгээгээ холбогдох байгууллагад мэдээлэгдэхээс зайлсхийж байгааг илэрхийлэхүйц асуулт асуух, хүсэлт тавих, эсвэл МҮЭ-ийн ажилтныг цааш мэдээлэхгүй байх талаар ятгах;
- Харилцагч амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний давуу тал, хүртэх ашиг болон нөхөн төлбөрийн хэмжээг сонирхохгүй, зөвхөн гэрээг цуцлах нөхцөл, эсвэл ашиг хүртэгч этгээдийг солих нөхцөл, эсвэл нэг дор өндөр дүнгээр хураамж төлөх үеийн гэрээний нөхцөл зэрэг бусад зүйлсийн талаар илүү сонирхох;
- Харилцагч эхний төлбөр төлсний дараа үндэслэлтэй тайлбар, шалтгаангүйгээр амь насны даатгалын гэрээг цуцлах.

### 3. САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагчийн гүйлгээний эрсдэлийг гүйлгээ хийгдэж байгаа арга хэлбэрээс хамаарч амь насны даатгалтай холбоотой даатгалын бүтээгдэхүүнийг гуравдагч этгээд ашиглах эсвэл уг бүтээгдэхүүнийг зориулалтаас нь өөр зорилгоор ашиглах эрсдэл хэр их вэ гэдгийг үнэлэх замаар тодорхойлж болно. МҮЭ нь амь насны даатгалын салбарт ашиглагдаж байгаа, харилцагчдад санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой санхүүгийн гүйлгээний эрсдэлийг ойлгож, мэдэх нь сэжигтэй гүйлгээ, үйлдлийг танихад дөхөмтэй. Харилцагчийн санхүүгийн гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүдийг дор харуулав:

- Харилцагчийн хийж байгаа гэрээ, худалдан авч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хийгдэж байгаа төлбөр тооцооны гүйлгээ нь харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаатай нь нийцэхгүй байх;
- Харилцагчийн даатгалын компаниас авч байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, төлбөрийн дүн, давтамж нь харилцагчийн ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, үйл ажиллагааны ердийн хэв маягтай нийцэхгүй байх (жишээлбэл, харилцагч нь оюутан, ажилгүй, тэтгэвэрт гэх мэт);
- Харилцагч өөрийн ажил, бизнес, орлогын байдлаас хэтэрсэн зөрүүтэй амьдрах;
- Харилцагч санхүүгийн үйл ажиллагааны хэв маягтай нь нийцэхгүй их хэмжээний мөнгийг амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулах;
- Харилцагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа эсвэл худалдан авдаг бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хэлбэр, хэв маяг гэнэт өөрчлөгдөх;
- Харилцагчийн оршин суудаг гэрийн хаяг болон ажилладаг газрын хаяг нь гадаад улсад байдаг хэрнээ үндэслэлтэй шалтгаангүйгээр Монгол Улсад амь насны даатгалд даатгуулж, гэрээ байгуулах;
- Харилцагч нь аяллын чек, нэрийн чек, өөр хүний нэр дээрх кредит карт эсвэл криптовалюта гэх мэт төлбөр тооцооны хэрэгслээр гүйлгээ, төлбөр хийх бөгөөд мөнгөний эх үүсвэр тухайн харилцагчид хамааралтай эсэх нь эргэлзээ төрүүлэх.

#### 4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

МҮЭ-ийн харилцагчдад санал болгодог даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зорилго, зориулалт, хэрэглэгчээс хамаараад эд хөрөнгийн, хуримтлалын, хариуцлагын, амь насны гэх мэт янз бүрийн төрөл, хэлбэр, зориулалттай байдаг. Албан журмын гэх мэт зарим даатгалын бүтээгдэхүүн МУТС эрсдэл багатай байдаг бол зарим бүтээгдэхүүн төрөл, шинж чанараасаа хамаарч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах эрсдэл өндөртэй байж болно гэж олон улсад үздэг. Энэ хэсэгт амь насны даатгалтай холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой шинж тэмдгүүдийн талаар мэдээлэл өгье. Зарим бүтээгдэхүүн, үйлчилгээ нь манай улсад байдаггүй байж болохыг анхаарна уу.

- Харилцагч хэд хэдэн даатгалын байгууллагад тодорхой шалтгаангүйгээр олон бүтээгдэхүүн эзэмшиж, үйлчилгээ авах;
- Харилцагч ажил, бизнесийн үйл ажиллагаа, өмнө үйлчлүүлж хэвшсэнтэй нийцэхгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглах;
- Харилцагч нь гуравдагч этгээд төлбөр, орлого хийх боломжтой эсвэл нүүр тулж харилцахгүйгээр мобайл аппликейшн гэх мэт эх үүсвэр, эзэн тодорхойгүй гүйлгээ хийх боломжтой амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь гэрээ цуцлахад торгууль, төлбөр байхгүй амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь тухайн бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг тодорхойлоход хэцүү амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь тухайн бүтээгдэхүүнийг хоёрдогч зах зээл дээр арилжаалж болдог эсвэл зээлийн барьцаанд тавьж болдог амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Харилцагч нь нэрээ нууцалж авч болдог амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ ашиглаж байгаа бол;
- Амь насны даатгалын бүтээгдэхүүнийг банкны данстай төстэй байдлаар ашиглах, тухайлбал нэмэлт премиум төлөх, хэсэгчлэн буцааж авах гэх мэт;
- Амь насны даатгалын гэрээний хугацааг өөрчлөх, энэ нь анхны зорилго, зориулалтаас нь өөрчлөгдөх;
- Харилцагч нь гэрээгээ өөр этгээдэд шилжүүлэх (урт хугацааны харилцааны дараа бага эрсдэлтэй боловч богино хугацааны дараа шилжүүлэх бол өндөр эрсдэлтэй бөгөөд ялангуяа өндөр дүнтэй гэрээтэй бол өндөр эрсдэлтэй);
- Харилцагч нь бүтээгдэхүүнийг хугацаанаас нь өмнө цуцлахын тулд өндөр дүнтэй зардал гаргах.



## 5. ГАЗАРЗҮЙН БАЙРШЛЫН ЭРСДЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

---

Газарзүйн байршлын эрсдэлтэй холбоотой сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүйг илтгэх шинжийг илэрхийлж болно. Зарим жишээг дор жагсаав. Үүнд:

- Харилцагчийн бүтээгдэхүүн худалдан авч буй байршил (эсвэл амь насны даатгалын байгууллагын төлөөлөгчийн байршил) болон харилцагчийн оршин суудаг байршил эсвэл бизнесийн байршил хоорондын зай хэтэрхий хол байх;
- Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон улс оронтой холбоотой үйл ажиллагаа, гүйлгээ хийгдсэн;
- Хөрөнгийн эх үүсвэр, орлогын эх үүсвэр эсвэл бусад мэдэгдэж буй харилцаа холбоо нь өндөр эрсдэлтэй улс орнуудтай холбоотой бол;
- Амь насны даатгалтай холбоотой даатгалын премиум, төлбөр, хураамжийг МУТС өндөр эрсдэлтэй улс орнуудад үүсгэн байгуулагдсан санхүүгийн байгууллагын дансаар хийх;
- Амь насны даатгалтай холбоотой даатгалын зуучлагч нь МУТС өндөр эрсдэлтэй улс оронд байрладаг эсвэл ийм улстай холбоотой байх.



## 6. ХЭВИЙН БУС ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагчийн өдөр тутмын бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас гадуур буюу түүнтэй нийцэхгүй гүйлгээнүүд хийгдэх нь бий. Эдгээр гүйлгээ нь сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг байж болох бөгөөд тэдгээрийг нарийвчилан хянаж, эрсдэлийг нь үнэлэх шаардлагатай байж болно. Хэвийн бус гүйлгээний зарим жишээг дор жагсаав:

- Харилцагчийн худалдан авсан амь насны даатгалтай холбоотой даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь түүний нөхцөл байдал, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх;
- Амь насны даатгалтай холбоотой даатгалын бүтээгдэхүүний хөрөнгө оруулалтын хэмжээ нь харилцагчийн эдийн засгийн байдалтай нийцэхгүй байх;
- Харилцагч нь богино хугацаанд дараалан өндөр дүнтэй бэлэн мөнгөөр амь насны даатгалын бүтээгдэхүүн худалдан авах, энэ нь шаардлагагүй, хэвийн бус санагдах;
- Нэг амь насны даатгалын гэрээний төлбөрийг хэд хэдэн өөр эх үүсвэрээс төлөх;
- Амь насны даатгалын гэрээг цуцалснаар үүсэх нөхөн төлбөр нь хамааралгүй гуравдагч этгээдэд шилжих;
- Харилцагч худалдан авалт хийсний дараахан тодорхой шалтгаангүйгээр хөрөнгө оруулалт эсвэл амь насны даатгалын гэрээг цуцалсан;
- Урт хугацааны даатгал /амь насны даатгал/-ын гэрээний хугацаанд даатгуулагчтай ямар нэгэн холбоогүй этгээдийг нөхөн төлбөр хүлээн авах этгээдээр нэрлэх, эсвэл гэрээнд өөрчлөлт оруулж солих;
- Амь насны даатгалын нөхөн төлбөр авч байгаа нөхцөл, шалтгаан нь сэжигтэй, хэвийн бус байх;
- Харилцагчийн амь насны даатгалтай холбоотой хийж байгаа гүйлгээ нь тодорхой бизнес, эдийн засгийн зорилгогүй байх;
- Амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ авч ашиглаж байгаа байдал нь гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаанд ашигладаг арга хэлбэр, типологитой нийцэх.



## 7. ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ ЭСВЭЛ ТАНИХ ШААРДЛАГААС ЗАЙЛСХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

МҮЭ-ийн гүйлгээ, харилцагчийг таньж мэдэх /цаашид “ХТМ” гэх/ эсвэл гүйлгээг эрх бүхий байгууллагад мэдээлэх шаардлагаас зайлсхийх, улмаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эсвэл бусад суурь гэмт хэрэг үйлдэх, эсвэл тэдгээр гэмт хэргээс олсон мөнгөө МҮЭ болон эрх бүхий байгууллагын хараа хяналтаас нуун далдлах зорилгоор зарим тохиолдолд харилцагч гүйлгээгээ хуульд заасан дүнгээс доогуур дүнгээр хэд хэд хувааж хийх явдал олон улсын практикт байдаг. Үүнтэй холбоотой зарим жишээг энд үзүүлэв:

- Харилцагч нь амь насны даатгалын хураамжийг бэлэн мөнгөөр эсвэл хуульд заасан мэдээлэх дүнгээс доогуур дүнгээр хэд хэд хувааж төлсөн бөгөөд хөрөнгийн эх үүсвэрийн талаар үндэслэлтэй тайлбар өгч чадахгүй байх;
- Бэлэн мөнгө, гадаад шилжүүлэг зэрэг өөр өөр төлбөрийн хэрэгсэл ашиглан амь насны даатгалын хураамж, төлбөр төлөх, төлөхийг хүсэх, энэ нь хэвийн бус санагдах;
- Урт хугацааны даатгал /амь насны даатгал/-ын премиум төлөх мөнгөний дүнг огцом хэмжээгээр нэмэх;
- Амь насны даатгалын гэрээнээс ашиг хүртэх этгээд нь даатгалын нөхөн төлбөрийг авч болох насанд хүрсэн бөгөөд даатгалын хураамжийг тогтмол бага дүнгээр төлөлгүй нэг дор их хэмжээгээр төлөх;
- Харилцагч хийж байгаа гүйлгээгээ холбогдох байгууллагад мэдээлэгдэхээс зайлсхийж байгааг илэрхийлэхүйц асуулт асуух, хүсэлт тавих;
- Харилцагч сэжигтэй гүйлгээг мэдээлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаар маш сайн судалж, мэдсэн байх;
- Харилцагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг сайн мэдэж байх;
- Харилцагч гүйлгээнд оролцож буй мөнгийг “цэвэр”, “хууль ёсны”, мөнгө угаахтай холбоогүй” гэж сайн дураараа, асуугаагүй байхад шууд хэлэх.

## 8. ГАДААД УЛС ОРОЛЦСОН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Харилцагчийн авч байгаа амь насны даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, нөхөн төлбөрийг шилжүүлж байгаа эсвэл хүлээн авч байгаа улс нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо сул хөгжсөн эсвэл олон улсын байгууллагын жагсаалтад орсон улс байж болно. Иймд МҮЭ нь дараах жишээнүүдийг анхаарч үзэх нь зүйтэй.

- Амь насны даатгалын төлбөрийг өндөр эрсдэлтэй буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хангалтгүй тогтолцоотой улс орноос шилжүүлсэн бөгөөд уг гүйлгээ нь харилцагчийн байдал, орлого эсвэл бизнестэй нь тохирохгүй байх;
- Амь насны даатгалын гэрээний данс нь оффшор компанийн нэр дээр ашиглагддаг эсвэл гаднын хуулийн этгээдийн эзэмшдэг оффшор дансыг дотоодын байгууллага ашигладаг ба уг дансаар тодорхой хугацаанд заасан дүнд хүрмэгц тогтмол шилжүүлэг хийгддэг байх;
- Гүйлгээнд холбогдох этгээдүүд нь гаднын улс орнуудад террорист эсвэл террорист бүлгэмийн гишүүн гэж тодорхойлогдсон, олон улсын байгууллагаас террорист этгээд гэж зарласан, эсвэл гүйлгээ хийсэн хөрөнгө нь террорист ажиллагаатай холбоотой гэж сэжиглэгдсэн эсвэл террорист үйл ажиллагаа, бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх үндэслэлтэй бол;
- Харилцагч нь олон улсын мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас өндөр эрсдэлтэй гэж зарлагдсан улс орон эсвэл авлига, мансууруулах бодис үйлдвэрлэл болон түүний худалдаа наймаа эрхэлдэг гэж танигдсан улс оронд байгуулагдсан гаднын зуучлалын болон бусад компанийг төлөөлж байвал;
- Амь насны даатгалын төлбөрийг оффшор банкаар дамжуулан хийж байгаа бол;
- Харилцагч өндөр дүнтэй даатгалын төлбөрийг гадаад валютаар эсвэл криптовалюта гэх мэт виртуал хөрөнгөөр төлөхийг хүсэх;
- Амь насны даатгалын зуучлалын байгууллагаар дамжуулан гаднын улс орноос өндөр дүнтэй даатгалын премиум, төлбөр шилжүүлэх.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх орчин нөхцөл, арга зам байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнийг дагаад өндөр эрсдэлтэй улс орнууд, чиг хандлага мөн өөрчлөгдөж байдаг. Иймд аль болох үнэн зөв, бодитой мэдээлэл ашиглаж байхын тулд олон нийтэд нээлттэй бөгөөд баталгаатай эх сурвалжуудыг тогтмол судалж байх нь зүйтэй. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй, эсвэл МУТСТ тогтолцоо нь стратегийн дутагдалтай улс орнуудын талаарх мэдээллийг нийтэлдэг, олон нийтэд мэдээлдэг ФАТФ гэх мэт албан эх сурвалжууд бий. Түүнчлэн террорист үйл ажиллагаа явагддаг, халдлага болдог эсвэл террористууд болон террорист бүлэглэлд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлдэг бааз суурь болдог гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаа улс орон, бүс нутаг руу МҮЭ-ээр дамжуулан мөнгө шилжүүлж эсвэл хүлээн авч болно. Иймд МҮЭ нь эрсдэл өндөртэй улс орнууд эсвэл мэдэгдэж буй чиг хандлагыг таньж мэдэх, тодорхойлох асуудлыг эрсдэлд суурилсан аргачлал, дотоод хяналтын хөтөлбөртөө тусгавал зохино.

## 9. БУСАД ТАЛУУДЫГ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

“Хэвийн” санхүүгийн гүйлгээ хийх явцад тухайн гүйлгээний мөн чанараас хамаарч “хэвийн” тооны оролцогч талууд гүйлгээнд оролцдог. Тухайлбал, банк, санхүүгийн байгууллага дахь хувийн харилцах дансанд орлого хийх тохиолдолд өөрийнхөө дансанд мөнгө хийж буй хүн буюу нэг тал энэ гүйлгээнд оролцоно. Харин бизнесийн буюу байгууллагын дансанд бэлэн мөнгөөр орлого хийх үед тухайн байгууллагын гүйлгээ хийх, гарын үсэг зурах эрх бүхий удирдах албан тушаалтан, эсвэл гүйлгээ хийх итгэмжлэл олгосон ажилтан, эсвэл зөвхөн орлогын гүйлгээ хийх үүрэгтэй ажилтан гэх мэт олон өөр хүмүүс энэ гүйлгээг хийж болно.

Тэгвэл гүйлгээ, үйл ажиллагаанд түүнтэй холбоотой байх боломжтой талуудаас өөр этгээд оролцох нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Гэмт этгээдүүд илчлэгдэхээс, эсвэл данс, хөрөнгө, мөнгөтэй холбоотой гэдгээ мэдэгдэхээс зайлсхийх зорилгоор эдгээр талууд буюу оролцогчдыг ашиглах нь бий. Гэхдээ энд харилцагч тодорхой шалтгааны улмаас гуравдагч этгээд, итгэмжлэгдсэн төлөөлөгч болон төлөөний хүн /харилцагчийг төлөөлөн санхүүгийн үйл ажиллагаа хийх эрх бүхий хуульч, ня-бо, бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэх мэт/-ийг ашиглах эсвэл хуулийн хүрээнд өөрийгөө төлөөлүүлэх, нэрийнхээ өмнөөс гүйлгээ хийж, санхүүгийн харилцаанд оролцох эрх олгож болохыг анхаарах нь зүйтэй.

Энэ хэсэгт амь насны даатгалын салбарын хувьд бусад талуудын оролцоо нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүйг илтгэж болох жишээнүүдийг жагсаалаа.

### Гуравдагч этгээдийг ашиглах:

- Харилцагч амь насны даатгалын гэрээний төлбөрөө гуравдагч этгээдээр хийлгүүлэх хүсэлт тавих;
- Харилцагч нь амь насны даатгалын үр шим, нөхөн төлбөрийг илт холбоо хамааралгүй гуравдагч талд шилжүүлэх;
- Харилцагч нь гэрээний заалтыг өөрчилж, илт холбоо хамааралгүй гуравдагч этгээдийг гэрээнд оруулах;
- Амь насны даатгалын гэрээ байгуулсан этгээдтэй илэрхий харилцаа хамааралгүй гуравдагч этгээдээс тогтмол төлбөр төлөгдөх;
- Харилцагч нь өөр этгээдтэй хамт ирж, түүний заавраар эсвэл хяналтан дор гүйлгээ хийх;

- Төлөөний хүн гүйлгээ хийх явцад үйлчлүүлэгчийнхээ мэдээллийг өгөх нь хэвийн үйл явц байх үед үйлчлүүлэгчийнхээ талаарх мэдээлэл өгөх, хэн болохыг нь мэдэгдэхээс зайлсхийх;
- Төлөөний хүн шаардлагагүй байхад гүйлгээг аль болох хурдан хийх арга зам хайж, гүйлгээ, үйлчилгээний зардал, шимтгэл хичнээн өндөр гарсан ч хамаагүй төлөөд хийх хүсэлт тавих.

### Төлөөний хүн ашиглах:

## 10. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дараах хэсэгт терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй зарим жишээг дурдлаа.

- Алан хядах бүлэглэлүүд үйл ажиллагаа явуулдаг, зэвсэгт мөргөлдөөн болж байгаа эсвэл түүнтэй ойрхон байршил, мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хяналт тавих сул тогтолцоотой гэх мэт өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг руу гүйлгээ хийх;
- Олонд танигдсан эсвэл сэжиглэгдэж байгаа террорист байгууллагатай холбоотой эсвэл холбоотой байж болзошгүй хуулийн этгээд, сан, холбооны нэрээр нээлгэсэн данс, түүгээр хийгдэх гүйлгээ;
- Ашгийн бус байгууллагын дансаа ашиглаж байгаа байдал нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, үүсгэн байгуулагдсан зорилгод нийцэхгүй байх;
- Албан бус эсвэл бүртгэлгүй хэлбэрээр хандив цуглуулах;
- Хэвлэл мэдээлэл, хууль сахиулах байгууллагаас харилцагч нь өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутгууд, ялангуяа мөргөлдөөн болж буй эсвэл улс төрийн тогтворгүй байдалтай байгаа эсвэл террорист үйл ажиллагаа, байгууллагыг санхүүгийн болон бусад байдлаар дэмждэгээрээ танигдсан улс орон, бүс нутгууд руу аялсан, эсвэл явахаар оролдсон, явах гэж байгаа талаар мэдээлэл гаргасан;
- Гүйлгээний аль нэг талд хориг арга хэмжээний жагсаалтад нэр тохирсон этгээд оролцсон;
- Гүйлгээг алан хядах байгууллага, террорист үйл ажиллагаатай холбоотой болохыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан хүн, хуулийн этгээд хийсэн;
- Хүн, хуулийн этгээдийг террорист байгууллага, террорист үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй гэж хууль сахиулах байгууллагаас мэдээлсэн;
- Харилцагч нь өндөр эрсдэлтэй улс орон, бүс нутаг, ялангуяа мөргөлдөөн болж буй эсвэл улс төрийн тогтворгүй байдалтай байгаа эсвэл террорист үйл ажиллагаа, байгууллагыг санхүүгийн болон бусад байдлаар дэмждэг гэдгээр танигдсан улс орон, бүс нутагтай холбоотой аялал жуулчлалын худалдан авалт хийсэн (жишээ нь, онгоцны тийз худалдан авсан, аяллын виз, паспортын төлбөр төлсөн гэх мэт);
- Хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн сошиал хаягуудаас харахад хүчирхийллийн хэт туйлшрах үзэл эсвэл радикалчлалыг дэмждэг болох нь харагдах.

----- o O o -----